"МОНГОЛЫН ПАРАГЛАЙДИНГИЙН ХОЛБОО"
БАТЛАВ
ТЭРГҮҮН ..... А.БАТДАВАА

МОНГОЛЫН ПАРАГЛАЙДИНГИЙН ХОЛБОО
ИНСТРУКТОРЫН ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТИЙН ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл:

1.1. Энэхүү журмаар Монгол Улсад параглайдингийн сургалтыг аюулгүй, чанартай, нэгдсэн стандартын дагуу явуулах зорилгоор инструкторын гэрчилгээжүүлэлт, эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулна.

1.2. Журмыг Монголын Параглайдингийн Холбоо (цаашид "МПХ" гэх) хэрэгжүүлнэ.

1.3. Энэхүү журам нь олон улсын туршлагад тулгуурласан бөгөөд зорилго нь дараах зүйлсийг тодорхойлоход оршино. Үүнд:

a) Инструкторын гэрчилгээжүүлэх хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох;
b) Инструкторын гэрчилгээжүүлэх хөтөлбөрийг тайлбарлах;
c) Инструкторын гэрчилгээ эзэмшихэд тавигдах шаардлагыг тодорхойлох.

ХОЁР. Инструкторын гэрчилгээжүүлэх хөтөлбөрийн зорилго:

2.1 Инструкторын гэрчилгээжүүлэх хөтөлбөрийн зорилго нь параглайдинг зааж буй инструкторууд дараах шаардлагыг хангаж буй эсэхийг баталгаажуулахад оршино. Үүнд:

a. заах гэж буй спортын төрлөө мэргэжлийн түвшинд эзэмшсэн байх;
b) орчин үеийн сургалтын арга барилын талаар хангалттай мэдлэгтэй байх;
c) МПХ-ны Ёс зүйн дүрмийг мөрдөх;
d) APPI холбооны системийг мэддэг байх.

ГУРАВ. Инструкторын гэрчилгээний түвшин:

3.1 Инструкторын гэрчилгээ нь дараах түвшинтэй байна. Үүнд:

a) Туслах инструктор (Apprentice Instructor)
b) Инструктор (Instructor)
c) Мастер инструктор (Master Instructor)

ДӨРӨВ. Инструкторын гэрчилгээ авахад тавигдах нийтлэг шаардлага:

4.1 МПХ-ны инструкторын гэрчилгээ авахад нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

a) МПХ-ны бүрэн эрхтэй, дүрмээ зөрчөөгүй гишүүн байх;
b) 21 ба түүнээс дээш настай байх;
c) Параглайдингаар МПХ-ны зэрэглэл P5 буюу түүнээс дээш зэрэглэлтэй, сүүлийн 24 сарын хугацаанд 200-с дээш цаг ниссэн байх;
d) Анхны тусламжийн хүчинтэй гэрчилгээ эзэмшсэн байх, эсвэл өөрийгөө эрүүл мэндийн мэргэжилтэн (сувилагч, эмч, яаралтай тусламжийн техникч) болохыг

нотолсон бичиг ирүүлэх бөгөөд анхны тусламжийн бэлэн байдал, ур чадвар нь тухайн мэргэжлийнх нь шаардлагад багтдаг байх.

e) Сүүлийн 12 сарын дотор, тухайн үйл ажиллагааны чиглэлээр гэрчилгээтэй Мастер инструктор (Master Instructor)-ийн удирдан явуулсан, хамгийн багадаа 3 өдрийн турш нийт 24 цаг үргэлжлэх Инструкторын гэрчилгээжүүлэх сургалтыг амжилттай дүүргэсэн байх;
f) Дээрх инструкторын сургалтыг амжилттай дүүргэсний дараа, 12 сарын хугацаанд, тухайн үйл ажиллагааны чиглэлээр гэрчилгээтэй Инструктор эсвэл Мастер инструкторт 25 с дээш цагийн турш туслан ажилласан байх;
g) Тухайн үйл ажиллагааны чиглэлээр гэрчилгээтэй Мастер инструкторын албан ёсны санал, зөвлөмжийг авсан байх;
h) APPI эсвэл МПХ-оос хүлээн зөвшөөрсөн олон улсын ижил түвшний шалгалт өгсөн байх;
i) Параглайдерийн бүтэц, үзлэг, ашиглалтын талаар сургалт авсан байх;
j) Паравинч буюу татлагатай гарааны зааварчилгаа өгөх мэдлэгтэй байх;
k) Ахисан шатны SIV буюу аюулгүй ажиллагааны сургалтад амжилттай хамрагдсан байх; (сертификат, зураг , бичлэг)
l) Тандем буюу зорчигчтой нислэгийг 50-с дээш удаагийн нислэг хийсэн байх, зохих мэдлэгтэй байх.

ТАВ. Инструкторын гэрчилгээг хадгалахад тавигдах шаардлага:

5.1 Инструкторын гэрчилгээг хүчинтэй байлгахын тулд инструктор 4 (a) болон 4 (e)-д заасан шаардлагыг үргэлжлүүлэн хангахын зэрэгцээ дараах нэмэлт шаардлагыг биелүүлнэ.

5.2 Хоёр жил тутам дахин гэрчилгээжих бөгөөд Инструкторын гэрчилгээг хүчинтэй байлгахын тулд тухайн инструктор нь энэхүү журмын 4 (a), 4 (d), 4 (e)-д заасан шаардлагыг тасралтгүй хангаж, 2 жил тутам дахин гэрчилгээжүүлэлтэд хамрагдана.

a) Инструкторын гэрчилгээ олгогдсон он, сар, өдөр нь тухайн инструкторын дахин гэрчилгээжүүлэх огноо болно.
b) Инструктор нь дахин гэрчилгээжүүлэх огнооноос өмнө МПХ-оос зохион байгуулсан Инструкторын семинар болон дахин гэрчилгээжүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан байна.
c) Дахин гэрчилгээжүүлэхэд дараах нөхцөлийг хангасан байна:
   - МПХ-ны бүрэн эрхтэй гишүүн байх;
   - Анхны тусламжийн хүчинтэй гэрчилгээтэй байх;
   - Сүүлийн 2 жилийн хугацаанд идэвхтэй нислэгийн болон сургалтын үйл ажиллагаа явуулсан байх;
   - МПХ-ны Ёс зүйн дүрэм болон аюулгүй ажиллагааны дүрмийг зөрчөөгүй байх;
   - МПХ-ны Инструкторын семинарт хамрагдсан байх.
d) Хэрэв инструктор дахин гэрчилгээжүүлэх хугацаандаа шаардлагыг хангаагүй бол тухайн гэрчилгээ нь дахин гэрчилгээжүүлэх огнооноос эхлэн хүчингүй болно.
e) Хүчингүй болсон гэрчилгээтэй этгээд нь инструкторын эрх эдлэх, сургалт зохион байгуулах, суралцагч үнэлэх эрхгүй болно.
f) Гэрчилгээ нь хүчингүй болсон этгээд гэрчилгээгээ сэргээх хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд тухайн этгээдийн нислэгийн идэвх, сургалтын туршлага, гэрчилгээ

хүчингүй болсон хугацааг харгалзан Мастер инструкторын саналын дагуу МПХ-ны инструкторын зөвлөл дахин гэрчилгээжүүлэх нөхцөлийг тогтооно.

g) Гэрчилгээ хүчингүй болсноос хойш 1 жилээс дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд тухайн этгээд гэрчилгээ авахад тавигдах шаардлагыг шинээр хангаж дахин гэрчилгээжүүлнэ.

ЗУРГАА. Мастер инструкторын гэрчилгээ авахад тавигдах шаардлага:

6.1 Параглайдингийн Мастер инструкторын гэрчилгээ авахын тулд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

a) МПХ-ны бүрэн эрхтэй, дүрмээ зөрчөөгүй гишүүн байх;
b) МПХ-ны Инструкторын зэрэглэлтэй байх ба уг зэрэглэлийг тасралтгүй 3 дээш жилийн хугацаанд эзэмшсэн байх;
c) 30-аас дээш суралцагчийг сургасан байх бөгөөд тэдгээр суралцагчид нь анхан шатны зэрэглэл (P1)-ийг авсан байх;
d) Параглайдингийн инструкторын гэрчилгээжүүлэх семинар зохион байгуулахад Мастер инструкторт туслан оролцсон байх;
e) Гэрчилгээтэй Мастер инструкторын санал, зөвлөмжтэй байх;
f) МПХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан Удирдах Зөвлөлд өргөдөл, хүсэлтээ ирүүлэх. Өргөдөл нь Удирдах зөвлөлийн зарим гишүүдэд өөрийгөө танилцуулах баримт бичиг болох тул нэр дэвшигчийн туршлага, мэргэжлийн талаарх холбогдох мэдээлэл болон яагаад энэхүү гэрчилгээг авахыг хүсэж буй шалтгааныг тодорхой тусгасан байна.
g) Сүүлийн 3 жилийн хугацаанд аюулгүй ажиллагааны ноцтой зөрчил гаргаагүй байх.
h) Хүсэлтийг МПХ-ны Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

ДОЛОО. Мастер инструкторын гэрчилгээг хадгалахад тавигдах шаардлага:

7.1 Мастер инструкторын гэрчилгээг хүчинтэй байлгахын тулд тухайн этгээд нь энэхүү журмын Зургаадугаар зүйлд заасан шаардлагуудыг үргэлжлүүлэн хангахын зэрэгцээ дараах нөхцөлийг биелүүлнэ. Үүнд:

a) Гурван жилийн хугацаанд нэгээс дээш удаа инструкторын сургалт, семинар, эсхүл инструкторын мэргэжил дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулсан, эсвэл зохион байгуулахад оролцсон байх;
b) МПХ-ны сургалт, аюулгүй ажиллагаа, дүрэм журам боловсруулах, тэмцээн уралдаан, нислэгийн талбай хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаанд хувь нэмэр оруулсан байх;
c) МПХ-нын бүрэн эрхтэй, дүрэм журам зөрчөөгүй гишүүн байх;
d) Сүүлийн нэг жилийн хугацаанд идэвхтэй нислэг үйлдсэн байх бөгөөд өөрийн нислэгийн бүртгэл (logbook)-ээр нотлох боломжтой байх;
e) Аюулгүй ажиллагааны ноцтой зөрчил гаргаагүй байх.

НАЙМ. Мастер инструктор болон инструкторын гэрчилгээ авах өргөдөл:

8.1 Инструктор болон мастер инструкторын гэрчилгээ авах хүсэлтэй этгээд нь энэхүү журамд заасан шаардлагыг хангасан болохыг нотлох холбогдох баримт бичгийг

бүрдүүлж, Мастер инструкторын санал, зөвлөмжийн хамт МПХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

8.2 Ерөнхий нарийн бичгийн дарга нь ирүүлсэн материалыг хянан үзэж, шаардлага хангасан гэж үзвэл МПХ-ны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулна.

8.3 Удирдах зөвлөл нь нэр дэвшигчийн материалыг хэлэлцэн, энэхүү журамд заасан шаардлагыг бүрэн хангасан гэж үзсэн тохиолдолд холбогдох инструктор эсвэл мастер инструкторын гэрчилгээг олгох тухай шийдвэр гаргана.

8.4 Удирдах зөвлөл шаардлагатай гэж үзвэл нэр дэвшигчээс нэмэлт мэдээлэл, тодруулга, эсхүл нэмэлт үнэлгээ шаардаж болно.

ЕС. Мастер инструктор болон инструкторын зэрэглэл алдагдах:

9.1 Мастер инструктор болон инструктор нь энэхүү журамд заасан гэрчилгээний хүчинтэй байдлыг хадгалах шаардлагуудыг хангахаа больсон тохиолдолд түүний гэрчилгээ хүчингүйд тооцогдоно.

9.2 Хүчингүй болсон гэрчилгээтэй этгээд нь инструкторын эрх эдлэх, сургалт зохион байгуулах, суралцагч үнэлэх, туслах инструктор удирдах эрхгүй.

9.3 МПХ-ны Удирдах зөвлөл нь дараах үндэслэлээр мастер инструктор болон инструкторын гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл цуцлах тухай шийдвэр гаргаж болно:

a) Аюулгүй ажиллагааны ноцтой зөрчил гаргасан;
b) МПХ-ны дүрэм, журам, ёс зүйн дүрмийг зөрчсөн;
c) Хуурамч мэдээлэл, баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;
d) Инструкторын үйл ажиллагаа нь суралцагчид, олон нийт, нислэгийн талбай, эсхүл спортын нэр хүнд, аюулгүй байдалд эрсдэл учруулсан гэж үзсэн;
e) Гэмт хэрэгт сэжигтэнээр татагдсан.
f) Инструкторын гэрчилгээг түдгэлзүүлэх, цуцлах асуудлыг Удирдах зөвлөл хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд тухайн этгээдэд тайлбар гаргах боломж олгоно.

АРАВ. Туслах инструктор: (Apprentice Instructor)

10.1 Туслах инструктор гэж гэрчилгээтэй инструктор эсвэл мастер инструкторын шууд удирдлага, хяналтын дор сургалтын үйл ажиллагаанд оролцож, инструкторын ур чадвар эзэмшиж байгаа этгээдийг хэлнэ.

10.2 Туслах инструкторыг энэхүү журамд заасан шаардлагыг хангасан тохиолдолд гэрчилгээтэй инструктор эсвэл мастер инструктор томилж болно. Томилгооны талаар МПХ-д мэдэгдэж бүртгүүлнэ.

10.3 Туслах инструктор нь бие даан сургалт зохион байгуулах, суралцагч үнэлэх, зэрэглэл олгох эрхгүй бөгөөд зөвхөн хариуцсан инструктор эсвэл мастер инструкторын удирдлага дор үүрэг гүйцэтгэнэ.

10.4 Туслах инструктор нь сургалтын үйл ажиллагаанд оролцох хугацаандаа инструктор эсвэл мастер инструктортой ил харааны болон радио холбооны шууд харилцаатай байна.

10.5 Туслах инструкторт инструкторын сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахыг мастер инструктор болон инструктор зөвлөнө.

10.6 Параглайдингийн Туслах инструктор болохын тулд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

a) МПХ-ны бүрэн эрхтэй, дүрэм журам зөрчөөгүй гишүүн байх;

b) Параглайдингийн Р3 буюу түүнээс дээш зэрэглэлтэй байх;
c) Аюулгүй ажиллагааны дүрэм, сургалтын үндсэн зарчмуудын талаар зохих мэдлэгтэй байх.

АРВАН НЭГ. Эрх олгох, томилох эрх хэмжээ:

11.1 Мастер инструкторын гэрчилгээ олгох асуудлыг МПХ-ны Удирдах зөвлөл хэлэлцэж шийдвэрлэнэ.
11.2 Инструкторын гэрчилгээ олгох асуудлыг мастер инструкторын санал, зөвлөмжийг үндэслэн МПХ-ны Удирдах зөвлөл хэлэлцэж шийдвэрлэнэ.
11.3 Туслах инструкторыг гэрчилгээтэй инструктор эсвэл мастер инструктор томилж болох бөгөөд томилгоог МПХ-нд мэдэгдэж бүртгүүлнэ.
11.4 Инструктор болон мастер инструкторын зэрэглэлд нэр дэвшигчийг санал болгох эрх нь мастер инструкторт хамаарна.

АРВАН ХОЁР. Мастер инструктор, инструкторын эрх, үүрэг, ёс зүйн хэм хэмжээ:

11.1 Мастер инструктор, инструктор нь дараах эрхтэй байна. Үүнд:
a) Энэхүү журам болон МПХ-ны холбогдох дүрэм, стандартад нийцүүлэн сургалт зохион байгуулах;
b) Суралцагчийн мэдлэг, ур чадварыг үнэлэх;
c) Суралцагчийн зэрэглэл олгох талаар санал гаргах;
d) Туслах инструктор томилж, удирдан ажиллуулах;
e) МПХ-ны сургалт, аюулгүй ажиллагаа, стандартын асуудлаар санал гаргах;
f) Мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар, арга хэмжээнд хамрагдах;
g) Сургалтын аюулгүй ажиллагааг хангах зорилгоор нислэгийг хойшлуулах, цуцлах, эсвэл зогсоох шийдвэр гаргах.
h) Мастер инструктор, инструкторын үүрэг

11.2 Мастер инструктор, инструктор нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
a) Суралцагч, зорчигч болон нислэгийн үйл ажиллагаанд оролцогчдын аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангах;
b) МПХ-ны дүрэм, журам, аюулгүй ажиллагааны заавар, ёс зүйн дүрмийг мөрдөх;
c) Сургалтын болон нислэгийн бүртгэлийг үнэн зөв хөтлөх;
d) Осол, зөрчил, аюултай нөхцөл байдлын талаар МПХ-нд тухай бүр мэдээлэх;
e) Сургалт болон нислэгийн үйл ажиллагаанд зөвшөөрөгдсөн талбай, орчин ашиглах;
f) Суралцагч, зорчигч, бусад нисгэгч болон олон нийттэй хүндэтгэлтэй, ёс зүйтэй харилцах;
g) Өөрийн мэдлэг, ур чадвар, мэргэжлийн түвшинг тогтмол дээшлүүлэх;
h) Суралцагчийн чадвар, туршлагад тохирсон сургалт явуулах;
i) Өөрийн эрүүл мэнд, бие бялдар, сэтгэлзүйн байдал нь аюулгүй сургалт явуулахад тохиромжтой эсэхийг үнэлж ажиллах.

11.3 Ёс зүйн шаардлага:
a) Шударга, хариуцлагатай, үлгэр жишээ байх;
b) Суралцагчийн нэр төр, хувийн мэдээлэл, аюулгүй байдлыг хүндэтгэх;
c) Ялгаварлан гадуурхах, доромжлох, дарамтлах аливаа үйлдэл гаргахгүй байх;

d) Ашиг сонирхлын зөрчил үүсгэхээс зайлсхийх;
e) Параглайдингийн спорт болон МПХ-ны нэр хүндийг хамгаалан ажиллах.

11.4 Хориглох үйл ажиллагаа:
Мастер инструктор, инструкторт дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:
a) Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэлийн нөлөөн дор сургалт явуулах, нислэг үйлдэх, эсвэл сургалтын үйл ажиллагаанд оролцох;
b) Суралцагч, зорчигч болон бусад этгээдэд бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн болон бусад хэлбэрийн дарамт, хүчирхийлэл үзүүлэх;
c) Худал мэдээлэл өгөх, нислэгийн болон сургалтын бүртгэлийг хуурамчаар үйлдэх;
d) Өөрийн эрх, зэрэглэлээс давсан сургалт, үнэлгээ хийх;
e) Аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг санаатайгаар зөрчих;
f) Суралцагчийг өөрийн чадвар, цаг агаар, тоног төхөөрөмжийн нөхцөлд үл нийцэх эрсдэлтэй нислэгт оролцуулах;
g) МПХ болон параглайдингийн спортын нэр хүндэд ноцтой хохирол учруулах үйл ажиллагаа явуулах.

11.5 Хариуцлага:


Энэхүү бүлэгт заасан эрх, үүрэг, ёс зүйн шаардлага болон хориглолтыг зөрчсөн тохиолдолд МПХ-ны Удирдах зөвлөлөөс сануулах, эрхийг түдгэлзүүлэх, гэрчилгээг хүчингүй болгох, эсхүл цуцлах хүртэл арга хэмжээ авч болно.

АРВАН ГУРАВ: Ерөнхий заалт:

13.1 Монгол Улсад параглайдингийн сургалтын аюулгүй байдал, чанар, нэгдсэн стандартыг хангах зорилгоор МПХ нь Инструкторын гэрчилгээжүүлэх тогтолцоог хэрэгжүүлнэ.
13.2 МПХ нь энэхүү журамд заасан шаардлагыг хангасан этгээдэд Инструктор болон Мастер инструкторын гэрчилгээ олгох бөгөөд гэрчилгээ эзэмшигч нь тухайн эрхийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөнө.
13.3 МПХ нь инструкторын гэрчилгээжүүлэлттэй холбоотой үндэсний сургалтын хөтөлбөр, зөвлөмж, стандартыг боловсруулж мөрдүүлж болох боловч сургалтын байгууллага, клуб, эсхүл инструкторын өдөр тутмын сургалтын үйл ажиллагаанд шууд хяналт тавих үүрэг хүлээхгүй.
13.4 Мастер инструктор, инструкторын гэрчилгээ нь тухайн этгээд гэрчилгээ олгох үеийн шаардлагыг хангасныг нотлох бөгөөд цаашдын сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүн, аюулгүй байдлын бүх хариуцлагыг МПХ хүлээхгүй.
13.5 Хэрэв мастер инструктор, инструктор нь суралцагчид, олон нийт, нислэгийн талбай, эсхүл спортын аюулгүй байдалд эрсдэл учруулсан, эсвэл МПХ-ны дүрэм, журам, ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн гэж үзвэл МПХ-ны Удирдах зөвлөл тухайн гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, эсхүл цуцлах тухай шийдвэр гаргаж болно.

Инструкторын гэрчилгээжүүлэлтийн журам баталсан

МПХ Удирдах зөвлөлийн гишүүд:



А.Батдаваа

Н.Мөнхбаяр

С.Очхүү

П.Бэхболд

Ц.Мягмардорж

Б.Болормаа

П.Болд

Б.Дарамжав

Г.Мөнхсайхан